



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2021 ОН



Улаанбаатар хот
2021 он


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшинг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүдэд дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

1.1. Зах зээлийн үнэлгээ


Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 оны жилийн эцсийн байдлаар 5.98 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 97.47 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 13.91 хувийг эзэлж байна.

График 1. Зах зээлийн үнэлгээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 180 компаниас 30 компанийн зах зээлийн үнэлгээ зах зээлийн үнэлгээний 93.67 хувийг бүрдүүлж байна.

График 2. ЗЗУ хамгийн өндөр 30 компани




1.2. Хөрвөх чадвар

Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын багтдаг ангилал буюу дунджаас бага орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 53.6 хувь байгаа¹ бол өндөр орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 98.6 хувь байна.

Монгол Улсын хувьд хувьцааны хөрвөх чадвар энэ оны жилийн эцсийн байдлаар 2.25 пунктээр өсөж 3.85 хувьд хүрсэн бөгөөд хувьцааны арилжаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.66 дахин өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

График 3. Хөрвөх чадвар /хувиар/



Хөрвөх чадварын үзүүлэлт олон улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад маш бага түвшинд байгаа нь голчлон хувьцааны төвлөрөлтэй хамааралтай байна.

1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

“Монголын хөрөнгийн бирж” ХК дээр ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 2021 оны жилийн эцсийн байдлаар 49,252.48 нэгж, доод үзүүлэлт 19,024.52 нэгж, дундаж үзүүлэлт 35,046.43 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25,125.8 нэгжээр буюу 130.28 хувиар өсөж 44,411.60 нэгж болсон байна.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-иас 2018 онд үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хамаарах MSE-A болон MSE-B индексийг тооцон гаргадаг болсон.

MSE-A индексийн дээд үзүүлэлт 2021 оны жилийн эцсийн байдлаар 15,482.77 нэгж, доод үзүүлэлт 8,630.36 нэгж, дундаж үзүүлэлт 11,438.34 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,360.76 нэгжээр буюу 69.73 хувиар өсөж 15,482.77 нэгж болсон байна. Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 13,309.64 нэгж, доод үзүүлэлт 7,337.79 нэгж, дундаж үзүүлэлт 11,119.50 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,621.43 нэгжээр буюу 60.96 хувиар өсөж 12,202.56 нэгж болсон байна.

¹ Stocks traded, turnover ratio of domestic shares (%)


Индекс	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт
ТОП 20	19,285.8	44,411.60	130.28%
MSE A	9,122.01	15,482.77	69.73%
MSE B	7,581.13	12,202.56	60.96%

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт

Тайлант хугацаанд нийт 1.41 их наяд төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн байна. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага дээр өмнөх онуудад зөвхөн хувьцаа, өрийн хэрэгсэл, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020 онд анх удаа хамтын хөрөнгө оруулалтын сан, 2021 оны 1 дүгээр улиралд хамгийн анхны нийтэд санал болгон гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас амжилттай арилжаалагдсан. Мөн энэ онд компанийн өрийн хэрэгсэл түлхүү гарч, компанийн өрийн хэрэгслийн арилжааны хэмжээ огцом өссөн бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 21.56 хувийг хувьцаа, 74.12 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 4.02 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 0.30 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна.

График 4. Үнэт цаасны арилжааны хэмжээ /бүтээгдэхүүний төрлөөр/



Нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.64 дахин өссөн бөгөөд компанийн бондын арилжаа 180.93 дахин өссөн нь Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгох чиглэлээр “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 692.5 тэрбум төгрөгийн бондын арилжаа голчлон нөлөөлсөн байна.

Харин хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд зөвхөн 6 төрлийн нийт 794.56 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 305.86 тэрбум төгрөгөөр буюу 62.59 хувиар өссөн байна.

2.1.1. Хувьцааны арилжаа


2021 оны жилийн эцсийн байдлаар 2 компани нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргасан. Үүнд:

“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК нь 2019 оноос хойших анхны IPO болсон ба тус компани нь нийт хувьцааны 16.87 хувийг олон нийтэд санал болгон гаргах замаар 28.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна. Харин “Богд банк” ХХК нь Банкны реформын хүрээнд нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргасан хамгийн анхны банк болсон ба тус компани нь нийт хувьцааны 20 хувийг олон нийтэд санал болгон гаргах замаар 31.75 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Мөн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн”-ийн нэмж гаргаж буй энгийн хувьцааг бүртгэсэн бөгөөд 14.25 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлснээр тайлант хугацаан дахь нийт анхдагч зах зээлд санал болгон худалдсан хэмжээ 74.70 тэрбум төгрөгт хүрээд байна.

Харин хоёрдогч зах зээлд нийт 230.26 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.74 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 5. Хувьцааны арилжаа



“Монголын хөрөнгийн бирж” ХК-аар 2021 онд нийт 248 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 146 хувьцаат компанийн 733.3 сая ширхэг хувьцааг 304.9 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Нийт 146 хувьцаат компанийн үнэт цаас арилжигдсанаас 92 компанийн үнэт цаасны ханш өсөж, 46 компанийн үнэт цаасны ханш буурч, 8 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна. Харин “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК-аар тайлант хугацаанд 383,300 ширхэг хувьцааг 24.7 сая төгрөгөөр арилжаалсан байна.

Хувьцааны арилжааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 180 компанаар ангилбал 30 компанийн хувьцааны арилжааны дүн нийт хувьцааны арилжааны 98.42 хувийг бүрдүүлж байна. Үүнд:

Хүснэгт 2. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөгөөр/

№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн	№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	86.36	16	“Монос хүнс” ХК	2.15
2	"МИК Холдинг" ХК	24.87	17	“Махимпекс” ХК	1.86
3	“Ард Кредит ББСБ” ХК	19.64	18	“Сентрал экспресс Си Ви Эс” ХК	1.56
4	“АПУ” ХК	17.77	19	“Тавантолгой” ХК	1.37
5	“Ард Даатгал” ХК	11.31	20	“Би Ди Сек” ХК	1.36
6	“Мандал даатгал” ХК	8.72	21	“Шивээ овоо” ХК	1.28
7	“Тэнгэрлиг медиа групп” ХК	7.61	22	“Сүү” ХК	1.22
8	“Түмэн шувуут” ХК	7.04	23	“Монгол шуудан” ХК	1.08
9	“Говь” ХК	5.62	24	“Жидакс” ХК	1.03
10	“Бодь Даатгал” ХК	5.09	25	“Шарын гол” ХК	0.85
11	“Инвекор ББСБ” ХК	5.00	26	“Дархан нэхий” ХК	0.66
12	“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК	3.36	27	“Мерекс” ХК	0.60
13	“Булган ундрага” ХК	2.93	28	“Монгол базальт” ХК	0.50
14	“ЛэндМН ББСБ” ХК	2.71	29	“Айтүүлс” ХК	0.50
15	“Улсын их дэлгүүр” ХК	2.16	30	"Баянгол зочид буудал" ХК	0.38
НИЙТ					226.59

2.1.1.1 Багцын арилжаа

Тайлант хугацаанд нийт 21 хувьцаат компанийн 156.4 сая ширхэг буюу 71.12 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 30.89 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Багцын арилжаа хийгдсэн компаниуд

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг /мян. ширхэг/	Үнийн дүн /тэр.бум төг/
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	2,476.68	16.17
2	“Ард Даатгал” ХК	890.11	0.87
3	“АПУ” ХК	1,753.41	2.53
4	“Люкс зананду групп” ХК	75.00	0.07
5	“Би Ди Сек” ХК	460.00	0.64
6	“Бодь Даатгал” ХК	32,466.67	4.17
7	“Булган ундрага” ХК	11.32	0.35
8	“Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК	519.26	0.02
9	“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК	786.26	0.79
10	“Говь” ХК	4,338.59	1.11
11	“Хөвсгөл” ХК	48.69	0.10
12	“Инвекор ББСБ” ХК	1,250.00	3.40
13	“ЛэндМН ББСБ” ХК	8,334.00	0.25
14	"МИК Холдинг" ХК	2,068.98	24.83
15	“Мандал даатгал” ХК	47,875.07	3.60
16	“Мерекс” ХК	27,601.29	0.59

17	“Өндөрхаан” ХК	127.11	0.15
18	“Шивээ овоо” ХК	557.92	1.23
19	“Стандарт агрикалчер групп” ХК	13,607.87	1.02
20	“Тэнгэрлиг медиа групп” ХК	1,175.63	7.19
21	“Түмэн шувуут” ХК	10,000.00	2.07
ДҮН		156,423.85	71.13

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

Тайлант хугацаанд компанийн бондын арилжаа 1.05 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 180.93 дахин өссөн үзүүлэлт юм.

График 6. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /хувиар/



Тайлант хугацаанд компанийн бондын арилжаа 1.05 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 180.93 дахин өссөн үзүүлэлт юм. Түүнчлэн 3 компани өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 720.05 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна. Үүнд: “Эрдэнэс таван толгой” ХК /ЭТТ бонд/ 692.5 тэрбум төгрөг, “Инвескор ББСБ” ХК /Инвескор бонд/ 20.0 тэрбум төгрөг, “Лэндмн ББСБ” ХК /Лэндмн бонд/ 7.5 тэрбум төгрөгийг тус тус татан төвлөрүүлсэн байна.

Харин компанийн өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлд 328.15 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн ба энэ нь нийт өрийн хэрэгслийн арилжааны 31.31%-ийг эзэлж байна.

График 7. Компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаа



2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойших хугацаанд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 31 хөрөнгө оруулалтын менежментийн компани тусгай зөвшөөрөл авсан байна.

Тайлан хугацаанд “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Мандал ирээдүйн өсөлт” ХОС анхдагч зах зээлд 47.50 сая ширхэг, 47.50 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нэгж эрхийг олон нийтэд амжилттай санал болгон худалдсан байна.

Харин хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд 28.28 сая ширхэг нэгж эрхийг 9.33 тэрбум төгрөгийн үнийн дүнгээр арилжаалсан байна.

2.1.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн биржээр нийт 794.56 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 305.86 тэрбум төгрөгөөр буюу 62.59 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд дараах 6 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



2.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК-аас 28 ТЗК үүсгэн байгуулж, нийт 83,539 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хороонд бүртгүүлээд байгаа бол 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 61,952 зээлдэгчийн 3.04 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

Мөн Ковид цар тахлын онцгой нөхцөлд ажиллаж буй төрийн албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны хөтөлбөрт хамруулах хүрээнд түрээсийн орлогод суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, шаардлагатай санхүүжилтийн шийдвэрлэхийг хууль болон УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор Засгийн газар, Монголбанк, Хороонд даалгасан. Хорооноос “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компаниудад түрээсийн орлогоор баталгаажсан буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгож, “НОСК нэг

ТЗК” ХХК-ийн 34.4 тэрбум, “НОСК хоёр ТЗК” ХХК-ийн 39.6 тэрбум, “НОСК гурав ТЗК” ХХК-ийн 13.9 тэрбум, “НОСК дөрөв ТЗК” ХХК-ийн 12.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгээд байна.

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хүрээнд уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгосон бага хүүтэй зээлээр баталгаажсан хөрөнгөөр баталгаажсан “ҮЦСК актив нэг ТЗК” ХХК-ийн 40.5 төгрөг, “ҮЦСК актив хоёр ТЗК” ХХК-ийн 168.0 төгрөгийн үнэт цаасыг тус тус бүртгэсэн.

Түүнчлэн 2010 онд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль батлагдсанаас хойш 10 гаруй жилийн хугацаанд энэ төрлийн үнэт цаасыг зөвхөн хаалттай хүрээнд цөөн тооны хөрөнгө оруулагчдад худалдахаар гаргадаг байсан бол 2020 онд арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулж, олон нийтэд анх удаа нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргасан. Тус шинэ бүтээгдэхүүнийг банк бус санхүүгийн байгууллагууд өөрсдийн үүсгэн байгуулсан ТЗК-аас дамжуулан гаргасан бөгөөд автомашины зээлээр баталгаажсан үнэт цаас гаргаж олон нийтээс 4.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

2.2. Үнэт цаасны зах зээлийн эрэлт


Тайлант хугацаанд 42,899 данс нээгдэж өссөн дүнгээр нийт 2,463,052 данс нээгдсэн байна. Мөн тайлант хугацаанд 84,652 холболтын данс нээгдэж нийт 516,245 холболтын данс нээгджээ.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

2021 оны нийт арилжаанд дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 74.34 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.86 функтээр өссөн, дотоодын иргэний хийсэн арилжаа 24.22 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.33 функтээр буурсан, гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 0.84 хувь буюу 0.34 функтээр өссөн, гадаадын иргэний хийсэн арилжаа 0.61 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.03 функтээр буурсан үзүүлэлттэй байна.

Гадаадын иргэний хийсэн арилжаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад огцом буурсан нь Ковид цар тахлын нөлөөтэй холбоотой байна.

График 8. Хөрөнгө оруулагчдын бүтэц /хувиар/



2.3. Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа

Хорооноос 2020 онд олон жил яригдсан боловч ажил хэрэг болж чадаагүй байсан биржийн бус зах зээлийн зохицуулалтыг орчныг тодорхой болгохоор “Биржийн бус зах

зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Биржийн бус зах зээл нь биржийн зах зээлтэй харьцуулахад мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцдог онцлогтой бөгөөд энэ нь үнэт цаас гаргах гэж буй компаниудад тавигдах шалгуур нь харьцангуй бага байх, үнэт цаас гаргах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг олон давуу талыг олгож байна.

Мөн Инновацийн тухай хуулийн 12¹ дэх заалтын дагуу “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулан баталсан бөгөөд цаашид гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргах боломжтой болсон.

2021 оны жилийн эцсийн байдлаар биржийн бус зах зээлд нийт 26 үнэт цаас гаргагч 36 өрийн хэрэгсэл гаргасан бөгөөд нийт 284.75 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

Хүснэгт 4. Биржийн бус зах зээлийн арилжаа /тэрбум төгрөг/

№	Үнэт цаас гаргагчийн нэр	Татан төвлөрүүлсэн дүн /тэрбум төгрөгөөр/
1	"Монкон групп" ХХК	15.00
2	"Гэрэл финанс" ББСБ	0.50
3	Бизнес инвестмэнт деволопмент ББСБ	1.00
4	"Альфа зон" ХХК	10.00
5	"Тера анлимитед" ХХК	0.70
6	"Хан" ХХК	3.00
7	"НВЦ Трейдинг" ХХК	7.00
8	"Говь" ХК	10.00
9	Монгол Улсын хөгжлийн Банк	142.46
10	"Нөмөр Кредит ББСБ" ХХК	2.00
11	"Кэй Эй Майнинг" ХХК	3.21
12	"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК	6.34
13	"Ти Ди Би Лизинг" ХХК	10.00
14	"Хөх Монгол Говь Транс" ХХК	3.00
15	"Бэрс финанс ББСБ" ХХК	4.20
16	"Төгс прогресс" ХХК	-
17	"Кредитех СТМ ББСБ" ХХК	1.00
18	"Төв Азийн зам" ХХК	4.00
19	"Ашид Капитал ББСБ" ХХК	10.00
20	"Гацуурт" ХХК	-
21	"Грийн индастри" ХХК	6.00
22	"Шунхлай" ХХК	-
23	"МИК ОССК" ХХК	34.20
24	"Инвескор ББСБ" ХК	3.74
25	"Жи эс би капитал ББСБ" ХХК	2.50
26	"Таван богд финанс ББСБ" ХХК	4.90
Нийт		284.75

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын

хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан 155, үнэт цаасаа бүртгүүлсэн 314 ХК, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг нь бүртгэсэн 23, үнэт цаасны зах зээлд хууль, үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн 110 этгээд байна.

Хүснэгт 5. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага*	2
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	31
5	Хамтын хөрөнгө оруулалтын сан	2
6	Кастодиан	3
7	Үнэт цаасны компани /брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх/	55 ¹
8	Хөрөнгө итгэмжлэн удирдах	7
9	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	1
10	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах	38
12	Хөдөө аж ахуйн бирж	1
13	Хөдөө аж ахуйн брокер	10
14	Өөрийгөө зохицуулах байгууллага*	2
Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн		
15	Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгээ бүртгүүлсэн	23
Бүртгэлтэй ХК-ийн тоо		
16	Хувьцаат компани	314
17	Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй*	179
Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд		
18	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	49
19	ҮЦЗЗ-д оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх	22
20	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх	39
Нийт		579

¹Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк орсон болно

*Давхардсан тоо

Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад зуучлах үйл ажиллагааны зөвшөөрөл авсан компаниудын талаар

Хорооноос гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад зуучлах үйл ажиллагааны зөвшөөрөл авсан нийт 13 ҮЦК байгаагаас 2021 оны байдлаар 6 ҮЦК нь 17,475 удаагийн хэлцлээр 1,264 харилцагчийн 1.10 их наяд төгрөгийн гадаад арилжаанд зуучилсан байна. Үүнээс “Толомт Капитал ҮЦК” ХХК нь хамгийн өндөр буюу нийт арилжааны 74.5%-ийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 6. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад зуучлах зөвшөөрөлтэй компани

№	Компаниуд	Нийт гадаад арилжааны дүн /сая төгрөгөөр/		Нийт хийгдсэн хэлцлийн тоо /гадаад арилжаа/		Нийт гадаад арилжаанд оролцсон харилцагчдын тоо
		Өөрийн нэрийн өмнөөс	Харилцагчийн нэрийн өмнөөс	Өөрийн нэрийн өмнөөс	Харилцагчийн нэрийн өмнөөс	
1	"Ард Секюритиз ҮЦК" ХХК	-	-	-	-	-
2	"Райнос инвестмент ҮЦК" ХХК	-	-	-	-	-
3	"Централ секюритиз ҮЦК" ХХК	-	-	-	-	-
4	"Голомт Капитал ҮЦК" ХХК	751.92	816,846.49	98	12384	792
5	"Мирэ эссет секьюритис Монгол ҮЦК"	-	-	-	-	-
6	"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК	1.73	42.71	21	250	105
7	"Апекс Капитал ҮЦК" ХХК	1,265.11	86,380.86	623	2650	217
8	"Гүүдсек ҮЦК" ХХК	-	-	-	-	-
9	"Мандал капитал маркетс" ХХК	-	1,562.50	-	470	83
10	"Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК	-	35,396.25	-	138	-
11	"Эм Ай Си Си"ХХК / МСС/	-	155,866.06	0	1,583	32
12	"Бидисек ҮЦК" ХК	1.57	-	446	0	35
13	"Таван богд капитал ҮЦК"ХХК	-	-	-	-	-
Нийт		2,020.33	1,096,094.87	1188	17475	1264

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

СЗХ-ноос 2021 онд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Банкны реформын талаар

УИХ-аас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Банкийг нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг энэ хуульд нийцүүлэн өөрчлөх, энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах хянах түр журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална” гэж заасан. Үүний дагуу Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А-50/53 дугаар хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.

Тус ажлын хэсгээс “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”-ыг боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.

Мөн Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11-д заасан “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчин шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгийн зүгээс “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хорооны цахим хуудсанд байршуулан олон нийт болон мэргэжлийн байгууллагуудын холбогдох саналыг аван, хуулийн төслийг эцэслэн боловсруулсан. Хуулийн төсөлд дээрх бодлого боловсруулагч байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоог хангах зорилгоор холбогдох зохицуулалтуудыг тусгасан бөгөөд Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 08-ны 75 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал”-ын жагсаалтад “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг хэлэлцэхээр тусгасан байна.

3. Үнэт цаасны бүртгэлийн зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлсэн талаар

Хөрөнгийн зах зээлд бизнес эрхлэгчдийн таатай орчинг бүрдүүлэх, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, түүний тогтвортой байдал, үр ашиг, ил тод байдлыг хангах зорилгоор Хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн найруулахын зэрэгцээ “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг шинээр боловсруулсан бөгөөд Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанаар уг журмуудыг баталсан.

Хөрөнгийн зах зээлд анх удаа анхдагч зах зээлийг андеррайтер төвтэй тогтолцоонд олон улсын жишгийн дагуу шилжүүлээд байна. Ингэснээр аж ахуйн нэгжүүд хямд зардлаар хөрөнгийн зах зээлд бонд, хувьцаа гаргах замаар урт хугацааны санхүүжилтийг татан төвлөрүүлэх боломж бололцоо бүрдэж байгаа юм.

Мөн хөрөнгийн биржийн I ангилал, ЗГ, МҮХАҮТ хамтран эрэмбэлсэн шилдэг 100 аж ахуйн нэгж, Хөгжлийн банк, ЗГ, эсхүл ЗГ-ын нэгдэн орсон ОУСБ-аас баталгаа гаргасан, 2 ба түүнээс доошгүй удаа нийтэд бонд гаргасан бол үндсэн болон хүүгийн нийт төлбөрийг бүрэн төлж дууссанаас хойш 12 сар өнгөрөөгүй компаниудын хүсэлтийг түргэвчилсэн журмаар биржийн дүгнэлтийг үндэслэн ажлын 10 өдөрт шийдвэрлэх, хөрөнгийн үнэлгээ хийлгэх асуудлыг зөвхөн шаардлагатай тохиолдолд хийлгэх боломжийг тусгаснаар цаг хугацаа хэмнэх, үнэт цаас гаргах зардал буурах зэрэг давуу талууд бий болсон.

Түүнчлэн олон улсад сүүлийн жилүүдэд эрчимтэй яригдаж буй ногоон санхүүжилт, ногоон хөрөнгийн зах зээлийг бий болгох чиглэлээр дотоодын аж ахуйн нэгжүүд Монгол Улсын “Ногоон таксономи”, олон улсын холбогдох стандарт, ангилал, шалгуурт нийцсэн төсөл, хөтөлбөрөө санхүүжүүлэх зорилгоор хөрөнгийн зах зээл дээр “Ногоон Бонд” гаргах боломжтой болсон.

Мөн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр нийтэд мэдээлэх мэдээллийг төрөлжүүлэн маягтжуулсны зэрэгцээ хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нэн шаардлагатай байдаг санхүүгийн тайлан, дүгнэлт, хууль зүйн дүгнэлт, үнэлгээний дүгнэлтийн чанарыг сайжруулах зохицуулалтуудыг тусгасан.

Үнэт цаасны бүртгэлийн зохицуулалтын орчны шинэчлэлттэй холбоотойгоор дэд бүтцийн байгууллагын дүрэм, журамд холбогдох өөрчлөлтийг оруулах чиглэлээр холбогдох үүрэг даалгаврыг өгсөн.

Үүний дагуу дээрх журмуудад нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулсан “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн “*Үнэт цаасны гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам*”, “*Үнэт цаасны хадгаламжийн журам*”, “Монголын үнэт цаасны бирж” хаалттай ХК-ийн “*Арилжааны журам*”, “*Бүртгэлийн журам*”, “*Шимтгэл хураамжийн журам*”, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “*Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам*”-ыг тус тус батламжилсан. Цаашид “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “*Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам*”, “*Үнэт цаасны бүртгэлийн журам*”-ыг батламжлах ажил хүлээгдэж байна.

4. Биржийн бус зах зээлийн суурь эрх зүйн орчин

Бондын зах зээлийн зохицуулалтын орчныг шинэчлэн сайжруулахтай холбоотойгоор хаалттай бондыг арилжаалах зах зээлийн зохицуулалтыг бий болгон, энэхүү зах зээлийг ил тод болгох чиглэлээр “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, батлуулсан. Ингэснээр компаниудын хувьд хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах эрх зүйн орчин бүрдэж, үнэт цаас гаргахад цаг хугацаа, зардал хэмнэхээс гадна хөрөнгө оруулагчийн зүгээс хаалттай өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээл үүсэх, үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах, мэдээллийн ил тод байдал хангагдах зэрэг чухал ач холбогдолтой юм.

Мөн Инновацийн тухай хуулийн 12¹ дэх заалтын дагуу гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргахтай холбогдсон харилцааг “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д нэмж тусган, журмын нэмэлт, өөрчлөлтийг Хорооны 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 348 дугаар тогтоолоор баталсан.

Биржийн бус зах зээлийн анхны арилжаа 2021 оны 9 дүгээр сарын 03-ний өдөр явагдаж, 3 үнэт цаас гаргагчийн 16.5 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 5 хаалттай бондын захиалга амжилттай биелсэн. Эдгээр бондын хоёрдогч зах зээлийн арилжаа 9 дүгээр сарын 07-ний өдөр эхэлснээр үнэт цаас гаргагчдын бондын хөрвөх чадвар сайжрах, өмчлөх эрхийн бүртгэл шилжих, арилжих боломж бүрдээд байна.

Биржийн бус зах зээлийн зохицуулалтын орчин бий болсноос хойших хугацаанд хувийн хэвшлээс уг зах зээлд компанийн бондыг 2021 оны 9 дүгээр сараас амжилттай гаргаж эхэлсэн бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 26 үнэт цаас гаргагчийн 36 өрийн

хэрэгслийн нийт 285.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа биржийн бус зах зээл дээр идэвхтэй явагдаж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР